

Харилцаа холбооны зохицуулах хорооны
20... оны ... дугаар сарын ... -ны өдрийн
... дугаар тушаалын хавсралт

ДОМЭЙН НЭР БҮРТГЭГЧИЙН МЭДЭЭНИЙ (3-ДНБ) МАЯГТ НӨХӨХ ЗААВАР

Домэйн нэр бүртгэгчийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь “Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журам”-ын 7.4-т заасны дагуу Зохицуулах хорооны батлагдсан маягтын дагуу хагас жилийн статистик тайлан мэдээллээ тухайн оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор, жилийн статистик тайлан мэдээллээ дараа оны 02 дугаар сарын 20-ны өдрийн дотор маягтад тодорхойлсон үзүүлэлтийн дагуу <http://stat.crc.gov.mn> хаягаар нэвтэрч, Зохицуулах хороонд ирүүлнэ.

Тайлант хугацаа гэж жилийн эцсийн тайлан, мэдээний хувьд өмнөх оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацааг, хагас жилийн тайлан, мэдээний хувьд тухайн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацааг ойлгоно.

МАЯГТЫН НЭР ТОМЪЁО, ТОВЧЛОЛЫН ТАЙЛБАР

НДШ гэж нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн нийт дүнг ойлгоно.

ААНОАТ гэж аж ахуйн нэгжийн орлогын албан татварт төлсөн нийт дүнг ойлгоно.

НӨАТ гэж нэмэгдсэн өртгийн албан татварт төлсөн нийт дүнг ойлгоно.

ХХОАТ гэж хувь хүний орлогын албан татварт төлсөн нийт дүнг ойлгоно.

I. ХАЯГИЙН ХЭСЭГ

Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын нэр, регистрийн дугаарыг улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсанаар товчлохгүйгээр нөхнө. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн оршин байгаа байр, хороо, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн нэрийг бичиж, Монгол Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн кодоос тохирох кодыг тус тус нөхнө.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын утасны дугаар, цахим шуудангийн хаяг болон тайлан, мэдээг хариуцан бөглөх ажилтны овог нэр, албан тушаал, утасны дугаар, цахим хаягийг тус тус нөхнө.

II. ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

БАГАНА Г: ХХЗХ-ны даргын 2022 оны А/335 тоот тушаалаар батлагдсан “Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс мэдээ, тайлан бүрдүүлэх, түгээхэд баримтлах журмын 9.2-т заасны дагуу “Н1- Нууц гэж үзэх ба ийм тэмдэглэл бүхий үзүүлэлтийг Зохицуулах хороо зөвхөн өөрийн үйл ажиллагаанд ашиглана.”, “Н2- Нээлттэй мэдээлэл гэж үзэх ба аж ахуйн нэгжийг дурдаж, нийтэд мэдээлж болно.”

БАГАНА 1: Тухайн үзүүлэлтийн утгыг нөхнө. Ингэхдээ хэмжих нэгж тус бүрийг нягтлах.

БАГАНА 2: Тухайн үзүүлэлт тус бүрд нэмэлт тайлбар, тодруулга бичиж тэмдэглэх шаардлагатай тохиолдолд тэмдэглэлийг тусгана.

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

МӨРИЙН ДУГААР:1 MN өргөтгөлтэй домэйн нэрийн тоо мөрөнд хэрэглэгчид олгосон MN өргөтгөлтэй домэйн нэрийн нийт тоог бичнэ.

Идэвхтэй домэйн нэр гэж бүртгэлийн мэдээлэл нь хүчин төгөлдөр байгаа, серверийн (DNS) тохиргоо хийгдсэн, вэб хуудас, цахим шуудан, бусад цахим үйлчилгээтэй холбогдон ашиглагдаж байгаа, домэйн нэрийн бүртгэлийн мэдээллийн санд “active”, “ok”, “clientTransferProhibited” зэрэг идэвхтэй төлөвийн утгатай бүртгээгдсэн домэйн нэрийг хэлнэ.

Идэвхгүй домэйн нэр гэж серверийн (DNS) тохиргоо хийгдээгүй, эсвэл домэйн нэрийн хугацаа дуусаж сэргээх, устгах шатанд байгаа, эсвэл “clientHold”, “serverHold”, “pendingDelete” зэрэг идэвхгүй төлөвийн утгатай бүртгээгдсэн, ямар нэгэн цахим үйлчилгээ (вэб хуудас, цахим шуудан гэх мэт)-тэй холбогдоогүй буюу бүртгэл нь хүчин төгөлдөр боловч ашиглагдаагүй, түр хугацаагаар идэвхгүй болгосон домэйн нэрийг хэлнэ.

МӨРИЙН ДУГААР:3 МОН өргөтгөлтэй домэйн нэрийн тоо мөрөнд хэрэглэгчид олгосон МОН өргөтгөлтэй домэйн нэрийн нийт тоог бичнэ.

МӨРИЙН ДУГААР:5 Дэд домэйн нэрийн тоо мөрөнд хэрэглэгчид олгосон дэд домэйн нэрийн нийт тоог бичнэ.

Дэд домэйн нэр гэж Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журмын 1 дүгээр хавсралтад заасан ангилал дахь GOV.MN, EDU.MN, ORG.MN зэрэг өргөтгөлтэй домэйн нэрийг хэлнэ.

МӨРИЙН ДУГААР:7 Бусад өргөтгөлтэй домэйн нэрийн тоо мөрөнд хэрэглэгчид олгосон бусад (com, net, biz гэх мэт) өргөтгөлтэй домэйн нэрийн нийт тоог бичнэ.

МӨРИЙН ДУГААР:9-12 Домэйн нэр эзэмшигчийн нийт тоо, эзэмшигчээр мөрөнд Домэйн нэр эзэмшигчийн нийт тоог гаргаж, эзэмшигчийг Аж ахуйн нэгж, байгууллага, Төсвийн байгууллага, Иргэнээр ялгаж нөхнө. Домэйн нэр эзэмшигчийн тоо буюу 9 дүгээр мөрийн дүн нь 10-аас 12 дугаар мөрүүдийн нийлбэр дүнтэй тэнцүү байна.

МӨРИЙН ДУГААР:13 Монгол Улсын төрийн үйл ажиллагаанд ашиглах нөөцөд бүртгэсэн домэйн нэрийн тоог бөглөхдөө Монгол Улсын төрийн үйл ажиллагаанд ашиглах, нутаг дэвсгэрийн нэгжийг илэрхийлэх эсвэл онцлох нэршил бүхий домэйн нэрийн нөөцийн жагсаалтад багтсан домэйн нэрийг бүртгэсэн тохиолдолд нийт тоог бичнэ.

ГОМДЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

МӨРИЙН ДУГААР:14 Хэрэглэгчээс ирүүлсэн нийт гомдлын тоог тооцохдоо тайлант хугацаанд хүлээн авсан домэйн нэрийн үйлчилгээтэй холбоотой бүх гомдлыг гомдлын хүчинтэй эсэх, сэдвээс үл хамааран багтаасан байна. Нэг хэрэглэгч нэг сэдвээр нэгээс илүү гомдол гаргах тохиолдолд гомдлын тохиолдол тус бүрийг тусад нь тоолно. Хэрэв үйлчлүүлэгч одоо байгаа гомдлыг хаахаас өмнө дахин гомдол гаргавал түүнийг тусдаа гомдол гэж үзэхгүй, харин эхний хаагдаагүй гомдлын үргэлжлэл гэж үзнэ. Гомдлын төрлөөр задалж, харгалзах мөрөнд бичнэ. *Хэрэглэгчээс ирүүлсэн нийт гомдлын тоо буюу 14 дүгээр мөрийн дүн нь 15-аас 17 дугаар мөрүүдийн нийлбэр дүнтэй тэнцүү байна.*

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО
Зах зээл, үнэ тарифын зохицуулалтын газар
Зах зээлийн судалгаа шинжилгээний хэлтэс

Утас: 11-304258

2025 он